

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан



***Байгаль орчныг хамгаалах талаар гарсан хуулийн хэрэгжилтэд
тавих хяналт хангалтгүй байна***

**Улаанбаатар
хот**

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

НАГ-ын дарга, Тэргүүлэх
аудитор
Б.Алтанзул

Менежер
Х.Болдбаатар

Шинжээч
О.Баярмаа
Г.Ганбаатар
Д.Дорждулам

2016 оны 12 дугаар сар
уг тайланг ҮАГ-ын веб
сайт-аас үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 261729
дугаарын утас, 260949
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр
байр,
Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар 15160,
Монгол улс

Товчилсон үгийн жагсаалт.....	2
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
Аудитын зорилт.....	3
Аудитын хамрах хүрээ.....	3
Аудитын эрсдлийн үнэлгээ.....	3
Арга зүй.....	3
Аудитын шалгуур үзүүлэлт.....	3
Ерөнхий мэдээлэл.....	5
БҮЛЭГ.1 АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ, ЗАСАГ ДАРГА БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА	7
1.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байна.....	7-8
1.2. Зарим аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	8
1.3. Зарим аймгуудын Засаг дарга нар байгаль орчныг хамгаалах талаар ИТХ-аас гаргасан шийдвэрийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.....	9
БҮЛЭГ.2 БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	10
2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт бодитой бус байна.....	10-11
2.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.....	11-16
БҮЛЭГ.3 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА	17
3.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаар мөрдөхгүй байна.....	17-18
3.2. Байгалийн ургамал, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуульд заасан хувь хэмжээгээр байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулаагүй байна.....	18-20
3.3. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуульд заасан хувь хэмжээгээр байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулаагүй байна.....	21-22
3.4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуульд заасан хувь хэмжээгээр байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулаагүй байна.....	23-24
3.5. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, болзол, хувь хэмжээг орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан хуульд заасны дагуу шийдвэрлэсэн байна.....	24
БҮЛЭГ.4 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА	25
4.1. Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.....	25-26
Дүгнэлт.....	27
Зөвлөмж.....	28
Холбогдох байгууллагын санал.....	29
Хавсралт.....	30-38
Тушаал.....	39

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОХТ	Байгаль орчныг хамгаалах тухай
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОНХ	Байгаль орчин, ногоон хөгжил
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗГ	Засгийн газар
ЗГБХН	Зарим гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НБОНХГ	Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар
НСТСХ	Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШУДАГ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УЦС	Усан цахилгаан станц
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ЦС	Цахилгаан станц
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан

Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, МУЕА-т 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтаар тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгал орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргээ биелүүлсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх;
- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад БОАЖЯ, түүний харьяа байгууллагууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, бүх шатны Засаг дарга, түүний харьяа байгууллага, татварын байгууллага, холбогдох аж ахуйн нэгжүүд хамрагдлаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000 болон Төрийн хяналт шалгалтын стандартыг ашиглалаа.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль;
- Ойн тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;
- Усны тухай хууль;

- Татварын ерөнхий хууль;
- Байгалийн ургамлын тухай хууль;
- Амьтны тухай хууль;
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”*;
- Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан *“Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”*;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, стандарт.

Ерөнхий мэдээлэл

Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага нь Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг 28 төрлийн хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж байна.

Мөн Монгол Ус ТӨҮГ, Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ, 30 Тусгай хамгаалалттай газар, 29 Сав газрын захиргаа зэрэг байгууллагуудаар байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Улсын хэмжээнд 2015 онд ус, рашаан, ой, ан амьтан, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого нийт 44,221.9 сая төгрөг төвлөрч, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 17,080.2 сая төгрөг зарцуулахаас 6,355.5 сая төгрөг зарцуулсан байна. (Хавсралт №1)

2016 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар ус, рашаан, ой, ан амьтан, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого нийт 18,757.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн ихэнх хэсгийг бүрдүүлж буй усны ашиглалт нь олон салбарт хамаарагддаг тул Усны тухай хуульд заасны дагуу усны асуудлаар салбар дундын зохицуулалт хийх, нэгдсэн удирдлагаар хангах, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах үүрэг бүхий “Усны үндэсний хороо”-г ажиллуулж байна. Засгийн газрын 2015 оны 409 дүгээр тогтоолоор тус хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, даргаар нь БОАЖ-ын сайд ажиллахаар болсон байна.

Усны талаарх асуудлыг доорх яамдууд чиг үүргийн хүрээнд хариуцан ажиллаж байна. Үүнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Усны нэгдсэн бодлого, усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах
Гадаад харилцааны яам	Олон улсын хамтын ажиллагаа, хилийн усны гэрээ, хэлэлцээр байгуулах
Сангийн яам	Төсөв санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх
Хууль зүй, дотоод хэргийн яам	Эрх зүйн шинэчлэл хийх асуудал
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Бэлчээр, тариалангийн усжуулалт, хүнс, хөнгөн үйлдвэрийн ус хангамж
Барилга, хот байгуулалтын яам	Хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	Сургалт, судалгаа
Зам тээврийн хөгжлийн яам	Усан замын тээвэр
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн ус хангамж
Эрүүл мэндийн яам	Усны чанар, эрүүл ахуй
Эрчим хүчний яам	Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх

ЗГ-ын 2013 оны 390 дүгээр тогтоолоор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр Монгол Ус ТӨҮГ гүйцэтгэж байна.

Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг БНАТ-ийн тухай хууль болон ЗГ-ын 2011 оны “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 302 дугаар тогтоол, 2013 оны “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” 326 дугаар тогтоол, мөн оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” /ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр/ 327 дугаар тогтоолыг үндэслэн усны сав газар тус бүрээр тогтоож байна.

2015 онд улсын хэмжээнд ус ашиглуулах дүгнэлтээр хэрэглэсэн, ашигласан усны хэмжээг 523 дүгнэлтээр 172,763,051 м³ ус ашиглах, хэрэглэхээр гарсан ба үүнээс БНАТ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1¹, 20.1.2², 20.1.3³, ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолд заасныг үндэслэн 56,090,415 м³ усыг төлбөрөөс хөнгөлөхөөр тооцсон байна.

БОНХАЖС-ын тушаалаар 2015 онд үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх байгалийн ургамлын дээд хэмжээг ховор ургамал 79,986 кг, элбэг ургамал 100,436 кг түүж

¹ Дараах зориулалтаар ус ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө: Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах;

² Түймэр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх;

³ Усыг үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигласан.

бэлтгэх зөвшөөрөл олгосон байна. Байгалийн ургамал, ойн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2,739.1 сая төгрөг бүрдүүлснээс, байгалийн ургамлын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 20.6 сая төгрөг зарцуулсан байна.

Байгалийн ховор ургамал дэрэвгэр жиргэрүүг Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн байна. Сүүлийн жилүүдэд эмийн зориулалтаар ургамлын үндсийг их хэмжээгээр түүж, гадаад гаргаж байгаа, бэлчээрийн талхагдалт, хээрийн түймэрт шатах зэргээс тархац эрчимтэй хумигдаж, нөөц улам бүр багасч, устаж болзошгүй аюулд хүрсэн байна.

2015.01.01-нээс 2016 оны 06.30-ны байдлаар 279,057 кг байгалийн ховор ургамал дэрэвгэр жиргэрүү, 4,795,515 кг хуш модны самар, самрын идээг гадаадад гаргасан байна.

БОНХАЖС-ын тушаалаар 2015 онд улсын хэмжээнд 33,709 га талбайгаас 1,097.1 мянган м³ мод бэлтгэх зөвшөөрлийн дээд хязгаарыг тогтоосноос, гүйцэтгэлээр 9,946 га талбайгаас 686.5 мян м³ мод бэлтгэсэн байна. 2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 3,635.6 сая төгрөг бүрдүүлснээс, ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 2,704.8 сая төгрөг зарцуулсан байна.

БҮЛЭГ.1 АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ, ЗАСАГ ДАРГА БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байна

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Салбарын хөгжлийн чиг баримтлалд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайлан тусгаж, байгаль хамгаалах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ зохион байгуулж үр дүнг Засгийн газарт тайлагнасан байна.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтэс Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан байгаль орчны улсын 22 мэдээллийн санг байгуулсан байна.

Дээрх мэдээллийн санд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагууд өөрийн гүйцэтгэсэн 4500 гаруй нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх авсан 900 гаруй байгууллагын эрхийн бүртгэлийн жагсаалт, байгалийн ургамлын экспортлох, импортлох, ашиглах 56 зөвшөөрлийн мэдээлэл, амьтны экспортлох, импортлох 104 зөвшөөрлийн мэдээг оруулсан байна.

2016 оноос ШУТС-аас хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, төсөл хөтөлбөрийн мэдээллийг энэхүү санд оруулж байна.

БНАТ-ийн тухай хууль болон Засгийн газрын 2013 оны “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” 326 дугаар тогтоолоор усыг цэвэршүүлэн, эргүүлж ашигласан нөхцөлд ус ашиглагч иргэн, ААНБ-ыг усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх болон хөнгөлөх эдийн засгийн урамшууллын нөхцөлийг бүрдүүлсэн нь усны үрэлгэн хэрэглээг багасгаж, усны нөөцийг хэмнэхэд чухал алхам болсон байна.

Хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

БОНХАЖ-ын сайд 2015 онд аймгийн Засаг дарга нартай байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Гэрээний хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322⁴ дугаар тогтоолын дагуу дүгнэсэн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Д/д	Аймгуудын нэр	Гэрээнд тусгасан нийт арга хэмжээ	Биелүүлээгүй тасарсан арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/
1	Архангай	24	-	87.6
2	Баян-Өлгий	20	1	68.4
3	Баянхонгор	21	1	82.2
4	Булган	48	-	83.0
5	Говь-Алтай	19	2	75.6
6	Говьсүмбэр	23	-	86.6
7	Дархан-Уул	16	-	87.9
8	Дорноговь	20	-	90.8
9	Дорнод	30	2	72.2
10	Дундговь	17	-	86.8
11	Завхан	22	-	93.3
12	Орхон	30	-	86.6

⁴ Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам

13	Өвөрхангай	21	-	82.7
14	Өмнөговь	32	4	70.1
15	Сүхбаатар	27	-	85.8
16	Сэлэнгэ	29	15	46.0
17	Төв	24	3	63.2
18	Увс	16	5	37.5
19	Ховд	23	2	54.1
20	Хөвсгөл	28	1	89.6
21	Хэнтий	40	-	82.9
	Нийт дүн	530	36	76.8

БОАЖ-ын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай “*нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах*” талаар “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан ч аймаг, орон нутгийн удирдлагууд гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

1.2 Зарим аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгийн ИТХ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсөв баталсан боловч биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй нь БОХТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1⁵, 16.2⁶, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4⁷, 17.2.4⁸ -т заасныг хэрэгжүүлээгүй байна.Тухайлбал:

- Төв аймгийн ИТХ-аас 2015 онд Мөнгөнморьт, Батсүмбэр сумдад хуваарилсан “Ойн цэвэрлэгээ хөтөлбөр”-ийн хүрээнд бэлтгэх модны хэмжээг Ойн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-д ИТХ-аас хуваарилахдаа түлээ бэлтгэх хэмжээг 13,460 м³ нэмэгдүүлж, хэрэглээний мод бэлтгэх хэмжээг 580 м³ бууруулж баталсан байна.

Дундговь аймгийн ИТХ нь нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг тогтоогоогүй байгаа нь БОХТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2⁹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Мөн Завхан, Баян-Өлгий аймгийн ИТХ аймгийн Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн санг БОХТ хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-6¹⁰ дахь заалтад заасан үзүүлэлтээр бүртгэн хүлээлгэн өгч, түүний өөрчлөлтийн тайланг жил тутам хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөөгүй нь БОХТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6¹¹-д заасныг биелүүлээгүй байна.

⁵ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих.

⁶ Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

⁷ Төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлах.

⁸ Тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

⁹ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2/ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох.

¹⁰ Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ:

1/ газар, түүний хөрс;
2/ газрын хэвлий, ашигт малтмал;
3/ ус, рашаан;
4/ ой;
5/ байгалийн ургамал;
6/ амьтан;

¹¹ Шинээр томилогдсон Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн санг энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-6 дахь заалтад заасан үзүүлэлтээр бүртгэж хүлээлгэн өгөх бөгөөд түүний өөрчлөлтийн тайланг жил тутам хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч байна.

1.3 Зарим аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар ИТХ-аас гаргасан шийдвэрийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна

Баянхонгор, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлсэн ч ИТХ-аас гарсан зарим шийдвэр болон БОХТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2¹²-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Мөн Баян-Өлгий аймагт Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэхэд шаардагдах төсөв батлах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны мэдээ тайланг нэгтгэн жил бүр ИТХ-д хэлэлцүүлэх ажлуудыг хийгээгүй, Дархан-Уул аймаг өмнөх онуудад жил бүр усны тооллого хийж ирсэн боловч 2015 онд усны тооллого хийх төсөв төлөвлөж, батлаагүйгээс усны тооллого хийгдээгүй зэрэг нь БОХТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7¹³, 16.2.8¹⁴, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3¹⁵ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

¹² Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах.

¹³ Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

¹⁴ Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8/нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

¹⁵ Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна.

БҮЛЭГ.2 БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт бодитой бус байна.

Аймаг, нийслэлийн 2015 оны төсөвт ус, рашаан, ой, ургамал, амьтны нөөц ашигласны төлбөрт 42,451.1 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж, 44,221.9 сая төгрөг, 2016 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар ус, рашаан, ой, ургамал, амьтны нөөц ашигласны төлбөрт 20,789.4 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж, (ТЕГ-ын тайлан мэдээнд тусгаснаар) 18,757.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна. (Хавсралт №2)

Нийслэл, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл аймгууд БНАТ-ын орлогыг төлөвлөхдөө нарийвчилсан судалгаа хийхгүй, үндэслэл муутай, зөвхөн өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан тодотгон баталсан байна. Тухайлбал:

- **Нийслэл**-Нийслэлийн татварын газар нь ус, рашааны, НБОНХГ нь ойн нөөц ашигласны төлбөрөөр нийслэл, дүүргийн төсөвт 2015 онд 1,963.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төсвийн саналаа НСТСХ-т хүргүүлсэн байна. Нийслэл, дүүргийн ИТХ-аар дээрх саналыг 1,055.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,019.2 сая төгрөгөөр баталсан,
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө 2014 онд татварын мэдээллийн баазад бүртгэлтэй 313.7 сая төгрөгийн төлбөр төвлөрүүлсэн ус ашиглагч 327 ААНБ-ыг хамруулаагүй,
- Зарим томоохон ААНБ-ын ус ашигласны төлбөрийг төлөвлөхдөө өмнөх онуудад ашигласан ус, ногдуулсан татварт тулгуурлаж тооцоогүй байна. Жишээ нь: Дулааны 3 дугаар ЦС 2014 онд 5.5 сая м³ ус ашиглаж 392.1 сая төгрөг төлсөн байхад 2015 онд 1.6 дахин их буюу 9.6 м³ ус ашиглахаар тооцож төлөвлөсөн,
- ЗГ-ын 2014 оны 307 дугаар тогтоолд “Цэвэрлэгээний огтлолтоос гарах жижиг хэрэглээний модны үнийг үндсэн төлбөрөөс 30 хувиар бууруулж тооцохоор заасан”-ыг зөрчин цэвэрлэгээний зориулалтаар олгох 600м³ шинэс модны үнийг хөнгөлөлтгүй үнээр тооцсоноос 1.4 сая төгрөг илүү төлөвлөсөн байна.

2015 оны БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:

/сая.төг/



Дээрх графикаас БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үзэхэд байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 1,795.0 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 976.1 сая төгрөгөөр давж биелсэн, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 594.0 сая, ойн нөөц ашигласны төлбөр 406.3 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарч нийт дүнгээр 1,770.8 сая төгрөгөөр төлөвлөгөө давж биелсэн байна.

Өмнөговь аймгийн БОАЖГ нь үйлдвэрлэлийн хүчин чадал, ТЭЗҮ-ийг үндэслэхгүй ус ашиглах дүгнэлтийг гаргасан нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5¹⁶-д заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

- Жавхлант орд ХХК-ийн 2015 оны 15/045 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг гаргахдаа хайгуулын ажлын төлөвлөгөөгөөр 15000 тууш метр өрөмдөхөөр төлөвлөснийг 5000 тууш метр болгон 10000 тууш метрээр буюу усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1.2 сая төгрөгөөр бууруулж гаргасан байна.

Говь-Алтай аймаг 2014-2016 онд ой, ургамал ашигласны орлогын төлөвлөлт нь үндэслэл муутай, харин гүйцэтгэлийг хангахын тулд хүү торгуулийн орлогыг зүйл анги зөрүүлэн тайлагнасан байна.

Нийслэлийн хэмжээнд ус, рашааны болон ойн нөөц ашигласны төлбөрөөр бүрдүүлэн тайлагнасан татварын орлогын гүйцэтгэлийг дансны хуулга, татварын мэдээллийн баазтай тулган шалгахад 2015 онд 23.5 сая төгрөгийн бусад орлогыг оруулж илүү тайлагнасан байна.

2.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна

Аймаг, нийслэлийн төсөвт 2015 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөр 35,814.6 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 3,635.6 сая төгрөг, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 2,739.1 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 2,032.6 сая төгрөг, нийт 44,221.9 сая төгрөг төвлөрүүлжээ. (*Хавсралт №1*)

2016 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөр 17,187.7 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 1,094.4 сая төгрөг, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 321.4 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 153.8 сая төгрөг, нийт 18,757.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6¹⁷, 23.8¹⁸-д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны төлбөрийг аймаг, нийслэлийн төсөвт, ан амьтан, байгалийн ургамал, ой, хүн амын унд ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөрийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж байна.

¹⁶ 28 Ус ашиглагчид олгох зөвшөөрөлд: 28.2 Ус ашиглах хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана: Үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үзүүлэлт;


¹⁷ Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр;

¹⁸ Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

- Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;
- Байгалийн ургамал ашигласны төлбөр;
- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;
- Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр;

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төрөл тус бүрээр нь графикаар харуулбал:

/сая.төг/



Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн талаар:

Зарим ус ашиглагч ААНБ-ууд ус ашиглах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулаагүйгээс ногдуулалт хийгдээгүй, ус, рашаан ашигласны төлбөр төлөгдөөгүй байгаа нь улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтнууд БОХТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3¹⁹, 27.1.7²⁰-д заасан эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18²¹, 29 дүгээр зүйлийн 29.1²², 31 дүгээр зүйлийн 31.1²³-д заасныг мөрдөхгүй байгаа зөрчил байна.Үүнд:

- **Баянхонгор** аймгийн Эрдэнэцогт сумын нутагт рашаан, сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Шаргалжуут рашаан сувилал” ХХК 2015 оны ус ашиглах дүгнэлтээ 2015.12.22-нд гаргуулсан, 2016 оны ус ашиглах дүгнэлт 2016.09.28-ний байдлаар гараагүй, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт хийгдээгүй,
- Мөн Өлзийт сумын нутагт 2014 оноос хойш рашаан, сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Баян-Зэндмэнь ундарга” ХХК-ийн Бага шаргалжуут рашаан сувилал нь 2014 онд ус ашиглах дүгнэлт гаргуулсан боловч ус, рашаан ашигласны төлбөрийг төлөөгүй, 2015, 2016 онд ус ашиглах дүгнэлт гаргуулаагүйгээс ногдуулалт хийгдээгүй, рашаан, ус ашигласны төлбөр төлөгдөөгүй,
- **Баян-Өлгий**-БОАЖГ-ын гаргасан 2014, 2015 оны судалгаагаар аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй гүний худаг эзэмшигч 24 ус ашиглагч ААНБ-аас 22 нь ус ашиглах дүгнэлтийг огт гаргуулаагүй, тоолуургүй ус ашигласан,
- **Ховд**-Эрэл хайгуулын Эф Ви Си Пи ХХК, Ашид алтай майнинг ХХК нь ус ашиглах зөвшөөрөлгүй ус ашигласан,
- **Өмнөговь**-Мөнхноён Суварга ХХК 2015 онд ус ашиглах дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулаагүй ус ашигласан,

¹⁹ Улсын байцаагч дараахь эрхтэй байна: Хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, тодорхой хугацаагаар үйл ажиллагааг нь түдгэлзүүлэн зогсоох;

²⁰ Улсын байцаагч дараахь эрхтэй байна: Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заасан захиргааны шийтгэл, нөхөн төлбөр ногдуулах, төлбөрийг барагдуулах;

²¹ Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно.

²² Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.

²³ Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.

- **Нийслэл**-Татварын мэдээллийн сан дахь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлсөн иргэн, ААНБ-ын судалгааг эрх бүхий байгууллагаас ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл авсан байгууллагын судалгаатай харьцуулахад 327 иргэн, ААНБ гэрээ байгуулахгүйгээр ус ашигласан байна.

Ус ашиглагч ААНБ-ууд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4²⁴, 28.11²⁵, 28.18²⁶, 30 дугаар зүйлийн 30.1.1²⁷, 30.1.4²⁸, 31 дүгээр зүйлийн 31.1²⁹, БОНХ-ын сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар баталсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасныг хэрэгжүүлээгүй, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Дд	Аймгийн нэр	ААНБ-ын нэр	Зөрчлийн утга	Зөрчлийн мөнгөн дүн /сая.төг/
1	Говь-Алтай	13 ААНБ	Ус ашиглах дүгнэлттэй, зөвшөөрөлтэй, гэрээтэй ААНБ-аас 2015-2016 онд усны нөөц ашигласны төлбөрийг буруу тооцож төвлөрүүлээгүй, ногдуулалт хийгээгүй.	69.8
2	Говь-Алтай	63 ААНБ	Усны дүгнэлтгүй, ус ашиглах зөвшөөрөлгүй ААНБ-ын ашигласан усны төлбөрийн хэмжээг нормын дагуу тооцоход 2015 -2016 онд дутуу тооцсон	32.1
3	Дархан-Уул	Дархан-Ус суваг ОНӨХК	БОАЖГ-тай хийсэн гэрээнд Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолд заагдсан аргачлалын дагуу тооцсоноор 141.3 сая төгрөгийн усны төлбөр төлөхөөр байсан гүйцэтгэлээр 68.6 сая төгрөг байгаа нь дээрх аргачлалыг мөрдөөгүй /2015 онд ашигласан нийт усны хэмжээ 496,028.8м³ усыг ангидал тус бүрээр салгаагүйгээс төлбөр дутуу тооцогдсон/.	72.7
4	Өмнөговь	Монголын алт МАК ХХК	5-р худгийн усыг унд ахуйн зориулалтаар бус тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээнд үйлдвэрлэлийн чиглэлээр зориулалт бусаар ашигласан	-
5	Өмнөговь	Монголын алт МАК ХХК	Шүүрлийн усыг зүмбэний аргаар хуримтлуулж усны машинаар зөөж, шавхан зайлуулалтыг хийхдээ баталгаажуулсан тоолуур суурилуулаагүй	-
6	Өмнөговь	Монголын алт МАК ХХК	Унд ахуйн хэрэглээний 5-р цооног тоолуурын хоорондох гол шугамаас салбарлаж усны крант гаргасан, 1 болон 2 дугаар худгаас ус цуглуулах гол шугам дээр баталгаажуулсан тоолуур суурилуулаагүй	-
7	Өмнөговь	Оюу толгой ХХК	Унд ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээг дүгнэлтэд зааснаас 2014 онд 193139м³, 2015 онд 72004м³ усаар хэтрүүлэн ашигласан	-
8	Өмнөговь	Өсөх зоос ХХК	Монгол ус ТӨААТҮГ-ын 2015 оны 15/01 дугаар ус ашиглах дүгнэлтийг үндэслэн Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглах гэрээн заасны дагуу усны нөөц ашигласны төлбөр дутуу төлсөн	8.9
9	Өмнөговь	Жавхлант Орд ХХК	Монгол ус ТӨААТҮГ-ын гаргасан 2015 оны 108 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн гэрээ байгуулаагүй, ус ашиглах зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж, усны нөөц ашигласны төлбөр төлөөгүй	19.4
10	Өмнөговь	Энержи ресурс ХХК	Монгол ус ТӨААТҮГ-ын 2015 оны 72 дугаартай ус ашиглуулах дүгнэлтэд заасан уурхайн ухалгаас шавхан зайлуулах усанд баталгаажуулсан тоолуур суурилуулаагүй, усны нөөц ашигласны төлбөр төлөөгүй	85.2
11	Өмнөговь	Саусгоби сэндс ХХК	Шүүрлийн усыг зүмбэний аргаар хуримтлуулж усны машинаар зөөж, шавхан зайлуулалтыг хийхэд баталгаажуулсан тоолуур суурилуулаагүй, усны нөөц ашигласны төлбөрийг бүрэн төлөөгүй	-
12	Хөвсгөл	-	Хөвсгөл нуурын усан мандлыг ашиглан нийт 67 орчим хөвөгч хэрэгсэл бизнесийн үйл ажиллагаа явуулан ашиг олж байгаа боловч ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, гэрээ байгуулаагүй, усны төлбөрийг төлөөгүй	-

²⁴ Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

²⁵ Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

²⁶ Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно.

²⁷ Ус ашиглагч дараах үүргийг хүлээнэ: Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

²⁸ Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах;

²⁹ Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.

13	Нийслэл	468 ААНБ	УСУГ-тай гэрээ байгуулан ус, рашаан ашиглаж байгаа хэрэглэгчдийн болон ашигласан усны судалгааг татварын мэдээллийн баазтай тулгахад 468 ААНБ ус, рашааны нөөц ашигласны татвар төлөгчөөр бүртгэгдээгүй, 2015 онд 813100 м3 ус ашигласан төлбөр төлөөгүй	161.6
14	Нийслэл	82 иргэн, ААНБ	Туул голын сав газрын захиргаа, НБОНХГ-аас 2013-2016 онуудад ус ашиглах дүгнэлт гаргуулсан 278 байгууллагаас 82 иргэн, ААНБ-тай НБОНХГ, дүүргүүдийн ЗДТГ гэрээ байгуулаагүй ба эдгээрээс 23 байгууллага усны нөөц ашигласны төлбөр төлөөгүй	36.9
15	Нийслэл	-	Үйлдвэрлэлийн зориулалттай 258 худаг ашиглагч гэрээ байгуулаагүй, ус ашигласны төлбөр төлөөгүй	-
16	Нийслэл	-	Туул голын сав газрын захиргаанаас 2013-2015 онд ус ашиглах дүгнэлт гаргаж, НБОНХГ гэрээ байгуулсан иргэн, ААНБ-аас 18 нь усны тоолуур суурилуулаагүй, Налайхаас бусад дүүрэгт ус ашиглах зөвшөөрөл олгосон байгууллагуудын тоолууртай эсэх талаар судалгаа байхгүй, хяналт хангалтгүй байна.	-
17	Ховд	13 ААНБ	Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгон, гэрээ байгуулсан ч усны нөөц ашигласны төлбөрөө төлөөгүй,	303.9

Нийслэлийн хэмжээнд олгосон ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулсан иргэн, ААНБ-ын дэлгэрэнгүй судалгаа НБОНХГ-т байхгүй, дүүргүүдийн БНАТ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3³⁰-д заасан албан тушаалтан 2014-2016 онд ус ашиглах гэрээ байгуулсан ААНБ-ын талаарх мэдээллийг татварын хэлтэст хүргүүлээгүйгээс 16 ААНБ татварын мэдээллийн баазад ус рашааны нөөц ашигласны татвар төлөгчөөр бүртгэгдээгүй байна.

Аймгуудын БОАЖГ, НБОНХГ болон дүүргийн ЗДТГ-ын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд Усны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2³¹, БОНХ-ийн сайдын 2014 оны А/86 дугаар тушаалаар баталсан “Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам”-ын 1.7-д заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс дээрх алдаа, зөрчлүүд гарсаар байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 58 хувийг бүрдүүлж буй Ус ашиглагч ААНБ-ууд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.18³², 30 дугаар зүйлийн 30.1.1³³, 31 дугаар зүйлийн 31.1³⁴ дэх заалтыг хэрэгжүүлээгүй, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн дээрх зөрчлийг арилгаж, нөхөн төлүүлэхээр 19.6 сая төгрөгийн акт, 1,147.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн талаар:

Ойн нөөцтэй зарим аймгууд Ойн нөөц ашигласны төлбөр төлөөгүй болон дутуу төлсөн байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.6, 18 дугаар зүйлийн 18.3.7, 38 дугаар зүйлийн 38.3³⁵ дахь заалтыг мөрдөөгүй байна. Тухайлбал:

- **Хөвсгөл** аймгийн нэр бүхий 8 суманд ахуйн зориулалтаар хуш модны самар түүх зөвшөөрөл олгосон ч түүж бэлтгэсэн самрын хэмжээ тоо баримтгүй, түүж бэлтгэсэн самрын төлбөрийг төлөгдөөгүй,
- **Булган** аймгийн Тэшиг сумын хэрэглээний мод бэлтгэсэн иргэн, ААНБ-аас ойн нөөц ашигласны төлбөр 23.4 сая төгрөг дутуу төлсөн, 40 айл өрх түлээний гоожингийн үнэ 0.9 сая төгрөг төлөөгүй, Бүрэгхангай сум мод бэлтгэлийн гоожингийн төлбөр 0.9 сая төгрөг дутуу төлсөн, Бугат сумын 4 иргэн, ААНБ ойн нөөц ашигласны төлбөр 3.4 сая төгрөг, нийт 28.6 сая төгрөгийн ойн, ойн баялгийн нөөц ашигласны төлбөр төлөгдөөгүй байна.

³⁰ Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.

³¹ Аймаг, нийслэлийн усны мэдээллийн санг бүрдүүлж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сав газрын захиргааг мэдээллээр хангах;

³² Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно.

³³ ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

³⁴ Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.

³⁵ Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ойн дагалт баялгийг төлбөртэйгөөр ашиглана.

Говь-Алтай аймгийн Халиун сумын ИТХ-аас өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд сумын албан байгууллагын хэрэгцээнд ойг цэвэрлэх журмаар мод бэлтгэх дээд хэмжээг 230м³ мод бэлтгэх тогтоол гаргасны дагуу сумын Засаг даргын захирамжаар 218.3м³ түлшний мод бэлтгэж, ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг ногдуулж 1.6 сая төгрөгийн орлого оруулсан нь Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.3 дахь заалтыг зөрчсөн тул бодит орлого гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Ойн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3³⁶ дахь заалтыг мөрдөөгүй ойн нөөц ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн зөрчлийг арилгах 31.1 сая төгрөгийн 11 албан шаардлага хүргүүлсэн байна.

Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн талаар:

Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус 73 дугаар хуралдааны тэмдэглэлд “байгалийн ховор ургамал дэрэвгэр жиргэрүүг Байгалийн ургамлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу экспортод гаргах” зөвшөөрөл олгохыг БОНХАЖ-ын сайдад даалгасан байхад 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс 2016 оны 6 дугаар сарын 30-ны хооронд Монгол Улсын хилээр 88,500 кг дэрэвгэр жиргэрүү ургамлыг гадаадад гаргаснаас байгалийн ховор ургамлын төлөх тэмдэгтийн хураамж 176.1 сая төгрөг, БНАТ 235.2 сая төгрөг, нийт 411.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна. (Хавсралт №3)

Тус ховор ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход төлбөр хураах хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.13³⁷-д зааснаар тооцсон байна. Экспортолсон дэрэвгэр жиргэрүү нь холбогдох мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн дүгнэлтээс харахад эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагддаг болох нь тогтоогдсон тул Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.17³⁸-д зааснаар тооцож үзэхэд 697.6 сая төгрөг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.



Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор дэрэвгэр жиргэрүүг ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн байна. Хэнтий, Хангай, Монгол дагуур, Хянган, Дундад халх, Дорнод монголын тойргуудад ургадаг бөгөөд сүүлийн жилүүдэд эмийн зориулалтаар ургамлын үндсийг их хэмжээгээр түүж, гадаад улсад удаан хугацаагаар гаргасан, бэлчээрийн талхагдалт, хээрийн түймэрт шатаж байгаагаас тархац эрчимтэй хумигдаж, нөөц улам бүр багасч, устаж болзошгүй аюулд хүргэсэн байна.

Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн ЗГХЭГ-ын 2015 оны 1 дугаар сарын 12-ны өдрийн ХЭГ/66, Сангийн яамны 2015 оны 4 дугаар сарын 9-ний өдрийн 4-1/1945 тоот албан бичгээр “ хуш модны самар нь ургамал биш хүнсний бүтээгдэхүүн” тул экспортлоход Байгалийн ургамлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1³⁹-д зааснаар зөвшөөрөл авах шаардлагагүй, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 219⁴⁰

³⁶ Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ойн дагалт баялгийг төлбөртэйгөөр ашиглана.

³⁷ Ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 1200-3000 төгрөг, тарималжуулсан нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 600-1500 төгрөг;

³⁸ Ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 4000-10000 төгрөг, ховор ургамлыг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 6000-15 000 төгрөг, түүхий эд бүтээгдэхүүн 20 000-50 000 төгрөг;

³⁹ Ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

⁴⁰ Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт

дүгээр тогтоолоор хязгаарласан барааны жагсаалтад ороогүй учир гаалийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх чиглэлийг өгсөн байна.

БОНХАЖС-ын 2015 оны 01/764 тоот албан бичгээр ГЕГ-т “... дээрх албан тоотууд нь гадаадад гаргах тухай шийдвэр биш болно, цаашид танай байгууллага хуш модны самар, түүний үр түүхий эд бүтээгдэхүүнийг гадаадад гаргах тус яамны тусгай зөвшөөрөлгүй иргэн, ААНБ-дад гаалийн бүрдүүлэлт хийхгүй байх” тухай анхааруулсан байхад 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2016 оны 6 дугаар сарын 30-ны хооронд 1,992,316 кг хуш модны самар, самрын идээг зөвшөөрөлгүйгээр улсын хилээр гарган, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 1,715.5 сая төгрөг, тэмдэгтийн хураамж 6,707.4 сая төгрөг, нийт 8,423.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна. (Хавсралт №4)

Байгалийн нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байгаа нь Байгаль орчныг хамгаалах талаар гарсан хуулиар олгогдсон хяналтын чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнууд хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүйгээс дээрх зөрчлүүд гарсан байна.

БҮЛЭГ.3 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА

3.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаар мөрдөхгүй байна

Улсын хэмжээнд 2015 онд ус, рашаан, ой, ан амьтан, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого нийт 44,221.9 сая төгрөг төвлөрсөн бөгөөд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 17,080.2 сая төгрөг зарцуулахаас 6,355.5 сая төгрөг зарцуулсан нь БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна. (Хавсралт №1)

БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁴¹-д байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаарыг тогтоосон бөгөөд 2015 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Аймгуудын нэр	Төвлөрүүлсэн орлого				Нийт дүн				Хуулийн хэрэгжилт /хувь/
		Ойн нөөц ашигласны төлбөр	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	2015 онд төвлөрүүлсэн БНАТ-ийн орлого	БОХ, НС арга хэмжээнд			
							Хуульд заасны дагуу зарцуулбал зохих /доод хязгаар/	ИТХ-аас баталсан	Зарцуулсан	
1	Архангай	357.2	1,578.0	112.9	6.5	2,054.6	583.1	316.2	256.6	44.0
2	Баян-Өлгий	28.1	-	16.3	306.5	350.9	182.8	60.1	48.2	26.4
3	Баянхонгор	-	-	116.1	6.3	122.4	43.8	54.9	167.2	381.9
4	Булган	306.8	3.9	11,423.6	31.2	11,765.5	4,275.2	5,130.3	972.5	22.7
5	Говь-Алтай	4.0	0.1	70.9	20.8	95.8	38.6	55.6	32.1	83.1
6	Говьсүмбэр	-	-	528.4	11.0	539.4	190.4	279.6	487.9	256.2
7	Дархан-Уул	39.1	0.1	397.0	-	436.2	172.2	210.1	32.2	18.7
8	Дорноговь	-	-	155.4	159.5	314.9	134.1	215.9	38.6	28.8
9	Дорнод	49.4	130.6	2,272.2	38.3	2,490.5	876.0	393.2	325.7	37.2
10	Дундговь	-	-	34.1	55.2	89.3	39.5	27.4	27.2	68.8
11	Завхан	181.7	15.0	255.2	35.1	487.0	263.6	170.2	119.2	45.2
12	Орхон	11.2	-	25.1	-	36.3	18.3	34.7	34.7	189,6
13	Өвөрхангай	823.8	-	300.0	336.7	1,460.5	973.6	164.9	164.9	16.9
14	Өмнөговь	0.1	-	13,666.1	-	13,666.2	4,783.2	4,562.7	1,766.8	36.9
15	Сүхбаатар	-	-	627.2	60.8	688.0	249.9	100.0	89.9	36.0
16	Сэлэнгэ	608.9	712.2	523.1	2.5	1,846.7	808.7	509.9	244.0	30.2
17	Төв	151.0	194.7	1,721.2	253.4	2,320.3	886.7	593.4	86.5	9.8
18	Увс	69.0	-	37.4	166.9	273.3	155.2	164.9	72.2	46.5
19	Ховд	12.9	23.7	76.0	143.8	256.4	113.0	129.0	66.9	59.2
20	Хөвсгөл	739.8	80.8	38.2	128.3	987.1	718.5	778.1	458.2	63.8
21	Хэнтий	252.6	-	408.1	269.8	930.5	492.4	329.5	172.8	35.1
22	Нийслэл	-	-	3,010.1	-	3,010.1	1,081.2	2,597.1	691.2	65.6
	Нийт	3,635.6	2,739.1	35,814.6	2,032.6	44,221.9	17,080.2	16,877,7	6,355.5	

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах,

⁴¹ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/

1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого-15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого-50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлого-15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого-85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого-35 хувь

тайлагнах журам"-ын 3-т заасныг мөрдөхгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалтын чанартай, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх нийтлэг арга хэлбэрт тусгагдаагүй ажилд, мөн төсвийн урсгал зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.Тухайлбал:

Д/д	Аймгийн нэр	Зориулалт бусаар зарцуулсан	Төсвийн урсгал зардалд зарцуулсан	Зөрчлийн утга
1	Архангай	117.0	-	·Эрдэнэмандал сумын ёслол хүндэтгэлийн талбай, ногоон байгууламж барих ажилд 50.0 сая төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан боловч анхан шатны баримт, ажлын төсөв, гүйцэтгэлийг шалгахад ёслол хүндэтгэлийн талбай барих барилгын ажилд зарцуулсан, ·Хяналтын техник, тоног төхөөрөмж, бие хамгаалах хэрэгсэлд 10.0 сая төгрөг, БЭГХУС камержуулалтын ажилд 50.0 сая төгрөг, байгаль хамгаалах хяналт шалгалтын унаанд 7.0 сая төгрөг, нийт 67.0 сая төгрөгийг зарцуулсан
2	Баян-Өлгий	-	186.8	·2015 онд нэр бүхий 13 сум 186.8 сая төгрөгийг төсвийн урсгал зардалд зарцуулсан.
3	Булган	-	-	·Эрдэнэт үйлдвэрээс усны төлбөр их хэмжээгээр ордог тул хуульд заасан хувь хэмжээгээр усыг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр зарцуулаагүй
4	Говьсүмбэр	54.1	-	·Ойн ангийн ажиллагсадын цалин, НДШ, томилолтын зардалд 40.8 сая төгрөг, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцаст 5.5 сая төгрөг, ойн ангийн услалтын системийн моторыг ажиллуулах, цахилгааны болон мод услах ус, шатахууны зардалд 7.6 сая төгрөгийг зарцуулсан
5	Дорнод	-	162.2	·ИТХ нь 162.2 сая төгрөгийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд хамаарахгүй төсөл арга хэмжээ болон урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталж зарцуулсан
6	Дорноговь	17.0	-	·Хөрөнгө оруулалтын чанартай Хамарын хийд орчмын байгаль хамгаалах ажилд зориулж ачааны автомашин худалдан авахад зарцуулсан
7	Сүхбаатар	156.0	-	·2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос орон нутгийн төсвийн алдагдлын нөхөх зориулалтаар зориулалт бусаар зарцуулсан зөрчил нь зуршил болж хэвшсэн
Дүн		344.1	349.0	

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, санхүүжилтийн задаргааг ИТХ хянаж батлахдаа Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын заасныг мөрдөхгүйгээр зориулалт бус ажилд тусган баталсан байна.

Өмнөговь аймгийн ИТХ 2015 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 4,562.7 сая төгрөг зарцуулахаар баталсан нь төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаар 35 хувьд хүрэхгүй, 220.2 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх 18 төсөл арга хэмжээнд 4,562.7 сая төгрөг зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 16 төсөл арга хэмжээнд 1,766.8 сая төгрөг зарцуулсан байна. Дээрхи арга хэмжээнээс 18,0 сая төгрөгийн өртөгтэй байгаль хамгаалагч нарыг тоног төхөөрөмжөөр хангах, 2,513.4 сая төгрөгийн өртөгтэй Даланзадгад сумын гэр хорооллын зарим хэсгийг цэвэр бохир усны шугамд холбох ажлууд зарцуулалтын эрх тавигдаагүй шалтгаанаар тухайн онд санхүүжилтийг шилжүүлээгүй байна.

3.2 Байгалийн ургамал, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуульд заасан хувь хэмжээгээр байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулаагүй байна

2015 онд байгалийн ургамал, ойн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуулийн дагуу зарцуулбал зохих доод хязгаар 410.9 сая төгрөгөөс, байгалийн ургамлын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 20.6 сая төгрөг, зориулалт бусаар 390.3 сая төгрөг зарцуулсан байна.

БОНХАЖС-ын тушаалаар 2015 онд үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх байгалийн ургамлын дээд хэмжээг ховор ургамал 79,986 кг, элбэг ургамал 100436, нийт 180422 кг байхаар тогтоосон байна.

БАЙГАЛИЙН УРГАМАЛ, ОЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙН ЗАРЦУУЛАЛТ



Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Сэлэнгэ, Төв аймаг байгалийн ургамал, ойн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх зардалд хөрөнгө төлөвлөж батлуулаагүй, зарцуулаагүй байгаа нь БНАТ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁴²-т заасныг биелүүлээгүй байна.

Дархан-Уул аймаг дахь “Батмөнх Заяамаа Нинжин” ЗГБХН-д БОНХАЖС байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл олгоогүй байхад 700 кг ургамал түүж бэлтгэсэн байна.


БОНХАЖС-ын 2015 оны А/338, А/367 дугаар тушаалаар тухайн жилд ойгоос хуш модны самар үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар түүж бэлтгэх зөвшөөрлийг олгохдоо зөвхөн түүж бэлтгэх сумын нэрийг зааж, бэлтгэх хэмжээг заагаагүй тул орон нутагт тухайн жилд түүж бэлтгэсэн нийт самрын хэмжээ болон хяналтын тоо бүртгэл хангалтгүй байгаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4⁴³-т заасныг хэрэгжүүлээгүй байна.

2015 онд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуулийн дагуу зарцуулбал зохих доод хязгаар 1,016.3 сая төгрөгөөс, ан амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 298.2 сая төгрөг зарцуулж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасныг мөрдөөгүй байна.

⁴² Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

⁴³ Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

**Ан амьтны нөөц ашигласны
төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт /2015 он/**



Дээрх графикаас үзэхэд Говьсүмбэр, Дорнод, Төв аймгууд ан амьтныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгө төлөвлөж, зарцуулаагүй, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд төлбөрийн орлогын хэсгээс 0.8–43.5 хувийг зарцуулсан нь БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй байгааг харуулж байна.

3.3 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуульд заасан хувь хэмжээгээр байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулаагүй байна

2015 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуулийн дагуу байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулбал зохих доод хязгаар 12,535.1 сая төгрөг зарцуулахаас, 3,331.9 сая төгрөг зарцуулсан байна.

Улсын хэмжээнд 2015 онд нийт 71,169,751 м³/жил хэрэглэсэн, ашигласан усанд төлбөр ногдуулснаас 9,236,016 м³/жил усыг төлбөрөөс чөлөөлж, нийт 61,933,735 м³/жил усны төлбөр төлсөн байна.

Дархан-Уул, Сэлэнгэ аймаг 2015 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2⁴⁴-т заасан арга хэмжээнд хөрөнгө төлөвлөж зарцуулаагүй байна.

Булган, Дорноговь, Дорнод, Завхан, Төв, Ховд аймаг ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 7.2-17 хувийг зарцуулсан нь БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасантай нийцэхгүй байна.

2015 оны ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Д/д	Аймаг	Хэрэглэсэн-ашигласан усны хэмжээ, м3/жил			Усны нөөц ашигласны төлбөрийн орлого /сая.төг/	БНАТ-ийн тухай хуулийн дагуу зарцуулбал зохих доод хязгаар /сая.төг/	Үүнээс:		Хуулийн хэрэгжилт /хувь/
		Төлбөр ногдуулсан усны хэмжээ /м ³ /жил/	Төлбөрөөс чөлөөлсөн усны хэмжээ /м ³ /жил/	Төлбөр төлсөн нийт усны хэмжээ /м ³ /жил/			Ус, рашаан хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан мөнгөн дүн /сая.төг/	Зориулалт бусаар зарцуулсан /сая.төг/	
1	Архангай	106,946		106,946	112.9	39.5	36.7	2.8	92.9
2	Баян-Өлгий	569,182	459,489	109,693	16.3	5.7	2.8	2.9	49.2
3	Баянхонгор	671,805	18,822	652,983	116.1	40.7	54.9	0.0	135.0
4	Булган	21,685,329	4,763,074	16,922,255	11,423.6	3,998.3	298.7	3,699.6	7.5
5	Говь-Алтай	476,959	439,551	37,408	70.9	24.8	12.0	12.8	48.4
6	Говьсүмбэр	4,701,328	194,922	4,506,406	528.4	184.9	270.6	0.0	146.3
7	Дархан Уул	6,155,428	1,666,337	4,489,091	397.0	139.0	0.0	139.0	0.0
8	Дорноговь	701,021	310,162	390,859	155.4	54.4	3.9	50.5	7.2
9	Дорнод	2,756,102	617,762	2,138,340	2,272.2	795.3	89.8	705.5	11.3
10	Дундговь	53,665	4,612	49,053	34.1	11.9	5.0	6.9	41.9
11	Завхан	253,235	0	253,235	255.2	89.3	15.2	74.1	17.0
12	Орхон	493,141	0	493,141	25.1	8.8	24.8	0.0	282.3

⁴⁴ Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.3-т заасныг үндэслэн:

- Усны сав газарт усны нөөцийн хайгуул судалгаа, зураглал хийх, усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд хяналт-шинжилгээ явуулах, усны тоо бүртгэл хийх;
- Усны үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг болон хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэрлэх, тоолууржуулах, унд-ахуйн ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг шинэчлэх, засч сэлбэхийг дэмжих, ундны ус цэнгэгжүүлэх, усны хяналт шинжилгээний болон лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, хаягдал ус зайлуулах цэгийг сайжруулах;
- Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийх, тохижуулах;
- Усны сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Усны сав газрын байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, цас, борооны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, рашаан, гол мөрний урсац бүрэлдэх эх, булаг шанд, баянбүрдийг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.

13	Өвөрхангай	1,148,812	114,746	1,034,066	300.0	105.0	100.2	4.8	95.4
14	Өмнөговь	16,204,166	337,962	15,866,204	13,666.1	4,783.1	1,766.8	3,016.3	36.9
15	Сүхбаатар	1,014,922	182,623	832,299	627.2	219.5	83.1	136.4	37.9
16	Сэлэнгэ	2,257,250	5,050	2,252,200	523.1	183.1	0.0	183.1	0.0
17	Төв	4,508,205	62,265	4,445,940	1,721.2	602.4	69.0	533.4	11.5
18	Увс	14,594		14,594	37.4	13.1	12.1	1.0	92.4
19	Ховд	487,381	58,086	429,295	76.0	26.6	3.0	23.6	11.3
20	Хөвсгөл	952,799		952,799	38.2	13.4	9.4	3.9	70.5
21	Хэнтий	44,845	556	44,289	408.1	142.8	84.5	58.3	59.2
22	Нийслэл	5,912,637		5,912,637	3,010.1	1,053.5	389.4	664.1	37.0
	Дүн	71,169,752	9,236,019	61,933,733	35,814.6	12,535.1	3,331.9	9,319.0	58.7

Хүснэгтээс үзэхэд аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга нар ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтад хуульд заасан хувь хэмжээг мөрдөхгүй байгаа нь БНАТ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁴⁵, 18 дугаар зүйлийн 18.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1⁴⁶-д заасантай нийцэхгүй байна.

Зарим аймгууд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулахаар төлөвлөсөн боловч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээнд бүрэн зарцуулаагүй, зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал:

- **Булган**-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс ус ашигласны төлбөрт их хэмжээний орлого орж ирдэг ч хуульд заасны дагуу зарцуулаагүй, *Төвлөрсөн хөрөнгийг жилийн эцэст төсөв батлахдаа мэргэжлийн байгууллага, сум, агентлагуудын санал, судалгаа тооцоог үндэслэн аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан хуваарийн дагуу зарцуулсан/*
- **Говь-Алтай**-АИТХ-аас 15.0 сая төгрөгийг урд бүсийн нэн ховор, ховор ашигт ургамлын судалгааны ажилд зарцуулсан,
- **Дорноговь**-Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 89.9 сая төгрөг зарцуулсан ба гүйцэтгэлийг авч үзвэл: 3.9 сая төгрөгийг усны тоо бүртгэл явуулах арга хэмжээнд зарцуулж, 86.0 сая төгрөгийг ойжуулалт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, эзэн холбогдогчгүй газрыг нөхөн сэргээх, хур хог хаягдал цэвэрлэх, хог хаягдлын нэгдсэн тоо бүртгэл явуулах, сумдад ажиллах идэвхтэн байгаль хамгаалагчийг цалинжуулах зэрэг арга хэмжээнд зарцуулсан,
- **Дундговь**-20.0 сая төгрөгийг ойн зурвас байгуулах ажилд зарцуулсан,
- **Сүхбаатар**-Ойн зурвас байгуулах, ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, мод үржүүлгийн газрыг өргөтгөх, тарьц, суулгац ургуулах, байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчдыг чадваржуулах, тоног төхөөрөмжөөр хангах, иргэдэд экологийн боловсрол олгох сургалт явуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, эвдрэлд орж орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх, туршилтын журмаар агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 82.6 сая төгрөг зарцуулсан,
- **Төв**-“Бүтэн байгуулалт төсөл”-ийн нэгжийн ажилчдын цалинд 54.9 сая төгрөгийг зарцуулсан.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4⁴⁷, 28.6⁴⁸-д заасны дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргаж, зөвшөөрөл олгон, гэрээ байгуулж, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг

⁴⁵ БНАТ-ийн тухай хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

⁴⁶ усыг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, нөхөн сэргээх, үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх;

⁴⁷ Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

⁴⁸ Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.

3.4 Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуульд заасан хувь хэмжээгээр байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулаагүй байна

2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс хуулийн дагуу зарцуулбал зохих доод хязгаар 3,117.9 сая төгрөгөөс, байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд ИТХ-аас 3,330.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 2,704.8 сая төгрөг зарцуулсан байна.

БОНХАЖС-ын тушаалаар 2015 онд улсын хэмжээнд 33,709 га талбайгаас 1,097.1 мянган м³ мод бэлтгэх зөвшөөрлийн дээд хязгаарыг тогтоосноос, гүйцэтгэлээр 9,946 га талбайгаас 686.5 мян м³ мод бэлтгэсэн байна.

Нийслэл, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Орхон аймаг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хувь хэмжээгээр, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3⁴⁹-т заасан арга хэмжээнд зарцуулж, хуулийн хэрэгжилт 96.9 дээш хувьтай биелсэн байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хууль, тогтоомжид заасан хувь хэмжээгээр зарцуулаагүй Архангай, Завхан, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Өвөрхангай, Төв, Хэнтий аймаг 7.1-67.0 хувийн биелэлттэй байгаа нь БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасантай нийцэхгүй байна.

Аймаг, нийслэлээс 2015 онд ойгоос бэлтгэсэн мод, ойн нөөц ашигласан төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын судалгааг хүснэгтээр харуулбал:

Д/д	Аймаг	Ойгоос бэлтгэсэн модны нийт хэмжээ /м3/	Ойн нөөц ашигласны төлбөрийн нийт орлого /сая.төг/	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хязгаар /сая.төг/	ИТХ-аас байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд батлагдсан дүн /сая. төг/	Үүнээс:	
						Ойг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан мөнгөн дүн /сая. төг/	Зориулалт бусаар зарцуулсан /сая. төг/
1	Архангай	93,590	357.2	303.6	262.6	203.3	50.0
2	Баян-Өлгий	8,260	28.1	23.9	44.2	44.2	0.0
3	Булган	95,635	306.8	260.8	900.6	663.8	0.0
4	Говь-Алтай	-	4.0	3.4	20.0	20.0	0.0
5	Говьсүмбэр	-	-	-	208.5	208.5	0.0
6	Дархан Уул	7,790	39.1	33.2	64.7	32.2	0.0
7	Дорнод	9,899	49.4	42.0	235.9	235.9	24.0
8	Завхан	71,694	181.7	154.4	98.0	98.0	0.0
9	Орхон	4,250	11.2	9.5	9.9	9.9	0.0
10	Өвөрхангай	19,309	823.8	700.2	49.5	49.5	650.7
11	Өмнөговь	-	0.1	0.1	-	-	-
12	Сэлэнгэ	87,542	608.9	517.6	242.8	242.8	266.9
13	Төв	33,754	151.0	128.4	5.6	17.5	10.4
14	Увс	18,974	69.0	58.7	30.0	30.0	21.6
15	Ховд	-	12.9	11.0	52.3	52.3	-
16	Хөвсгөл	187,380	739.8	628.8	668.9	419.2	19.2
17	Хэнтий	42,133	252.6	214.7	141.1	75.9	149.6
18	Нийслэл	6,300	0.0	27.6	295.5	301.8	8.7

⁴⁹ Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.4-т заасныг үндэслэн:

- Аймаг болон тухайн сумын ой зохион байгуулалт хийх, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, нөхөрлөл, ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дэмжих;
- Ойн хөнөөлт шавж, өвчний хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, суурин судалгаа хийх;
- Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраах;
- Ойн үр бэлтгэх ой сонгох, плантаци байгуулах, үр, боргоцой бэлтгэж боловсруулах, тарьц, суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн зурвас, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, голын эх, эрэг дагуу мод тарьж төгөл байгуулах, баянбүрд бий болгох, хууль бус мод бэлтгэх зөрчлийг бууруулах, хяналт шалгалт хийх арга хэмжээнд тус тус зарцуулна.

	Нийт дүн	686,510	3,635.6	3,117.9	3,330.1	2,704.8	1,201.1
--	----------	---------	---------	---------	---------	---------	---------

Ой хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу төлөвлөгдсөн хөрөнгөөс 1,201.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасантай нийцэхгүй байна.

3.5 Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, болзол, хувь хэмжээг орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан хуульд заасны дагуу шийдвэрлэсэн байна

Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг хууль, журамд заасны дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулсан байна.

БНАТ-ийн тухай хуулийн 19⁵⁰, 20⁵¹, 21⁵², 22⁵³ дугаар зүйлд байгалийн ургамал, ус, ой, амьтны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх зориулалт, хэлбэрийг тусгасан байна.

2015 онд БНАТ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1⁵⁴, 21 дугаар зүйлийн 21.2⁵⁵, 2014 оны 307 дугаар тогтоолд заасныг үндэслэн ой, ус ашигласны төлбөрөөс хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн байна. Тухайлбал:

- **Нийслэл**-Унд ахуй, газар тариалан, мал усалгааны зориулалтаар ашигладаг 4938 гүний худгийг ашиглагч байгууллага иргэдэд ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдуулаагүй, татвараас чөлөөлсөн,
- **Нийслэл**-Ойн цэвэрлэгээний зориулалтаар бэлтгэсэн 600м³ шинэс модны 10.8 сая төгрөгийн төлбөрөөс хуульд заасны дагуу 30 хувь буюу 3.2 сая төгрөгийг хөнгөлөлтөд хамруулсан байна.

Улсын хэмжээнд 2015 онд нийт 71,169,751 м³ нийт ус ашигласан, хэрэглэсэн ба үүнээс БНАТ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2⁵⁶, 20.1.3⁵⁷, ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолд заасныг үндэслэн 9,236,016 м³ усыг төлбөрөөс хөнгөлсөн байна. (Хавсралт №5)

ИТХ байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг батлахдаа хуулийн дагуу тогтоосон хэмжээг мөрдөөгүй, Засаг дарга нар төлөвлөлт хийж ИТХ-д өргөн барихдаа дутуу төсөвлөдөг, батлагдсан хөрөнгийг зориулалт бусаар төсвийн урсгал зардалд зарцуулсан зөрчил гаргасан байна.

⁵⁰ Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

⁵¹ Усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

⁵² Ойн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

⁵³ Ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

⁵⁴ Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах;

⁵⁵ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглавал төлбөрийг хөнгөлж болох бөгөөд хөнгөлөлтийн хувь, хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

⁵⁶ түймэр унтраах болон байгалийн бусад гамшигтай тэмцэх;

⁵⁷ усыг үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигласан.

БҮЛЭГ.4 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА

4.1 Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна

Байгаль орчныг хамгаалах талаар хууль, тогтоомжид заасны дагуу дотоод хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбооноос шалтгаалан хяналтын ажлын үр дүн орон нутагт хангалтгүй байна. Тухайлбал:

- Орон нутгийн түвшинд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн орчин байгаа боловч хяналтын тогтолцоо нь өөр өөр байгууллага, агентлагуудад хуваагдсан байдалтай байна. *Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4-т зааснаар аймгийн Засаг дарга, 26 дугаар зүйлийн 26.1-т МХГ, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т сум, дүүргийн Засаг дарга, Усны тухай хуулийн 17.1.10-т Сав газрын захиргаа, Усны тухай хуулийн 18.1.3-т аймаг, нийслэлийн БОАЖГ хяналт тавихаар заасан,*
- Аймгийн БОАЖГ хяналт тавьж байгаа боловч хуулиар олгогдсон эрхийн дагуу БО-ны улсын байцаагч нь Шадар сайдын харьяа агентлаг болох МХЕГ-т харьяалагдаж байгаа тул БОАЖГ хяналт тавих эрх хязгаарлагдмал, гарсан зөрчилд газар дээр нь хариуцлага тооцож арга хэмжээ авч чаддаггүй,
- Усны тухай хуулиар БОАЖГ хяналт тавихаар заасан боловч Усны сав газрын захиргаа нь өөрийн нутаг дэвсгэрт харьяалагдаж байгаа гэдэг үүднээс давхар хяналт тавих,
- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д зааснаар ус ашиглах зөвшөөрөл олгох эрхийг **гурван** даргад өгсөн нь усны тухай хуулийн хэрэгжилт, бодлого, хяналт нь орон нутгийн түвшинд нэгдсэн байдлаар хэрэгжиж чадахгүй байх үндэслэл болсон,
- Эдгээр хяналтын чиг үүрэг бүхий эрхтэй байгууллагууд нь: БОАЖГ, Монгол ус ТӨҮГ, Сав газрын захиргаа зэрэг байгууллагууд нь хоорондоо ажлын уялдаа холбоо муутай үл ойлголцох явдал гардаг байна.

Сав газрын захиргаа, БОАЖГ, МХГ, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нь хуулиар олгосон байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг хэрэгжүүлэн хамтарч ажиллах уялдаа холбоо муутай, санаачлагагүй ажиллаж байна. Тухайлбал:

- **Дархан-Уул**-Усны хэрэглээг тоолуурын заалтаар тайлагнадаг ч түүнд тавих хяналт хангалтгүй,
- **Өмнөговь**-БОХТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу хяналтыг аймгийн МХГ хэрэгжүүлж байна. 2015 оны 1-р улиралд “Саусгоби Сэндс” ХХК, “Чинхуа мак-Нарийн сухайт” ХХК, Цагаан өвөлжөө ХХК-иуд, 3-р улиралд “Энержи ресурс” ХХК, Эрдэнэс таван толгой ХХК, Таван толгой ХК-дад дэд бүтэц, хөдөлмөр нийгмийн хамгаалал, байгаль орчин, геологи, уул уурхайн чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан ч Усны тухай хуулийн хэрэгжилт, ус, рашааны нөөц ашиглалтад хийсэн хяналтын тайлан байхгүй,
- **Сүхбаатар**-БОАЖГ-ын мэргэжилтнүүд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд байгаль хамгаалах тухай хууль зөрчсөн ААНБ, албан тушаалтан, иргэдэд хариуцлага тооцох улсын байцаагчийн эрхгүй улмаас МХГ, Цагдаагийн газартай хамтран хяналт шалгалт явуулж арга хэмжээ авдаг,
- **Сүхбаатар**-Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нь БОАЖГ, МХГ-тай хамтарч ажиллах уялдаа холбоо муутай, байгаль орчныг хамгаалах тухай хуулиар олгосон улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэн ажиллах талаар санаачлагагүй, үр дүн муутай ажиллаж байна.

Аудитаар өгсөн акт, албан шаардлагын дүн:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитад нийт 595 байгууллага хамрагдсанаас тухайн хугацаанд залруулах боломжтой зөрчлийг арилгуулж ажилласан ба залруулах боломжгүй, зайлшгүй төлбөрийн акт, албан шаардлага бичих шаардлагатай 98.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 19 төлбөрийн акт тогтоож, 44 байгууллагын 53 албан тушаалтанд 3,721.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, хариуцлага тооцуулах, албан шаардлага хүргүүллээ. (Хавсралт №6)

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Зарим аймгийн ИТХ, Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
2. Аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, гүйцэтгэлийг буруу тайлагнасан, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт хангалтгүй, эрх бүхий байгууллагууд мэдээллээ бүрэн солилцдоггүй байна.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хууль, тогтоомжид заасны дагуу мөрдөөгүй байна.
4. Орон нутгийн ИТХ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, санхүүжилтийн задаргааг хянаж батлахдаа ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолыг баримтлахгүй байна.
5. Үйл ажиллагааны зарим чиглэлд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн ч биелэлт, үр дүнг тооцож ажиллаагүй байна.
6. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо дутмагаас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт:

1. Тайланд дурьдагдсан байгалийн ховор ургамал дэрэвгэр жиргэрүү, хуш модны самар, самрын идээг зөвшөөрөлгүй экспортолноос улсын төсөвт бүрдүүлэх их хэмжээний орлогын эх үүсвэрийг бүрэн төвлөрүүлээгүй нь ЗГХЭГ, БОАЖЯ, СЯ, ГЕГ зэрэг байгууллагуудын ажлын уялдаагүй байдлаас шалтгаалсан бөгөөд цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

БОАЖ-ын сайдад:

1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд Байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан чиг үүргийг бүрэн тусгах, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцдог эрх зүйн орчин бүрдүүлэхэд анхаарах;
2. Байгаль орчныг хамгаалах хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын мэдээлэл солилцох механизмыг боловсронгуй болгох, ажлын уялдаа холбоог сайжруулах;
3. Ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулаагүй иргэн, ААНБ-ын судалгааг гаргаж, гэрээ байгуулах;
4. Ой, байгалийн ургамлын нөөцгүй, орлого олох боломжгүй аймгийн хувьд “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.1-3.4-т тухайн нөөцөөс орсон орлогын хэсгийг тухайн төрөл, зүйлд нь эргүүлэн зарцуулахаар заасныг бүс нутгийн онцлогт тохируулан бусад орлогын төрлүүдээс гүйлгэн зарцуулах боломжийг судлан шийдвэрлэх.

Гаалийн ерөнхий газарт:

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн байгалийн ховор ургамал дэрэвгэр жиргэрүү, хуш модны самар, самрын идээний экспортын гаалийн бүрдүүлэлт хийхдээ Байгалийн ургамлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтын дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрлийг шалгаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:**Тайлбар 1.**

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх судалгааг 2014 оны 1 дүгээр сарын 1-ээс 2016 оны 6 дугаар сарын 30-ны хоорондох хугацаагаар хязгаарлаж аудитад хамрах хүрээг тогтоосон тул саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулав.

Тайлбар 2.

ЗГХЭГ, Сангийн яам хууль бус шийдвэр гаргаж үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн хуш модны самар, самрын идээний экспортын гаалийн бүрдүүлэлт хийлгэх тухай ЗГХЭГ-ын 2015.01.12-ны өдрийн ХЭГ/66, Сангийн яамны 2015.04.09-ны өдрийн 4-1/1945 албан тоот Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн тул саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулав.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА А.ЗАНГАД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2016.12.13 № 01/2831

танай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн тайлантай танилцлаа. Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын дагуу тайланд тус яамны саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Бүлэг 1, Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны дутмаг байдал бүлгийн 1.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн талаарх мэдээлэлд заасан /10 дугаар хуудас 19-26 мөр/ Засгийн газрын 2014 оны 122 дугаар тогтоолоор 2014 онд тусгай зориулалтаар 41 толгой тэх агнахаар заасан бөгөөд Байгаль орчин, ногоон хөгжилт, аялал жуулчлалын яамнаас 50 тэхийн зөвшөөрөл олгож, 47 тэхийг агнасан байдаг. Дээрх олгосон зөвшөөрлийн зөрүү болох 9 тэх нь 2013 онд агнаагүй үлдсэн тэхийг аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан 2014 онд олгосон зөвшөөрөл дээр нэмж олгосон байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор олгосон тоо хэмжээг хэтрүүлэн олгосон зөвшөөрөл биш нөхөж олгосон зөвшөөрөл болно.

2. Тайлангийн 1 бүлэг 1.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл/11-р хуудас, 22-р хуудас 8-15 мөр/-д заасан хуш модны самрын идээг зөвшөөрөлгүйгээр гаргаснаас 8.423.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, зөрчил гарсан талаар дурдсан байна. Дээрх асуудал нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас зөвшөөрөл олгогдоогүй байхад Гаалийн ерөнхий газраас Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2015.01.12-ны өдрийн ХЭГ/66 дугаар албан тоотыг үндэслэн хуш модны самрын идээг зөвшөөрөлгүй гаргасан, 8.423.0 сая төгрөг төсөвт төвлөрүүлээгүй зэрэг үйлдэл нь Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Гаалийн ерөнхий газарт хамааралтай зөрчил болно.

Иймд дээрх 2 асуудлыг танай байгууллагаас хийсэн "Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангаас хасуулах саналтай байна.



Д.ОЮУНХОРОЛ



Хавсралт №1

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт

/сая.төг/

Д/д	Аймагуудын нэр	Байгалийн нөөцийн төрөл												Нийт дүн				Хуулийн хэрэгжилт /хувь/
		Ой		Байгалийн ургамал		Ус, рашаан		Ан амьтан		2015 онд төвлөрүүлсэн БНАТ-ийн орлого		БОХ, НС арга хэмжээнд						
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	Ой хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	Байгалийн ургамал хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	Ус, рашаан хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд	Зарцуулбал зохих	Зарцуулсан орлого	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	Ан амьтан хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд	Зарцуулбал зохих	Зарцуулсан орлого	ИТХ-аас баталсан	Зарцуулсан					
1	Архангай	357.2	303.6	203.3	1578.0	236.7	2.3	112.9	39.5	36.7	6.5	3.3	14.3	2,054.6	583.1	316.2	256.6	44.0
